



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/110

Алтай хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 -ын "А" дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.


2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, явц үр дүнг тухай бүр танилцуулж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Ц.Эрдэнэбат)-т даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ


Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 23 ны өдрийн 4110 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хэрэгжүүлэгч байгууллага	
							Үндсэн	Хамтрагч
Нэг. Олон нийтийн хяналтыг эрчимжүүлэх, энэхүү ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагуудын үүрэг, оролцоог ханган баталгаажуулах, идэвх санаачилгыг дэмжиж, байгууллагуудын авлигын эсрэг хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах								
1.	Төрийн албаны салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох	Дүгнэлтийг gov-altai.gov.mn, байгууллага бүр өөрийн вэб сайт болон мэдээллийн самбарт тавих.	Жилдээ	-	-	Дүгнэлтүүд нээлттэй, ил тод болсон байх	Аймгийн Төрийн албаны салбар зөвлөл, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс	Агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар
2	Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны	Байгууллага, хэлтсийн ил тод байдлын самбарт мэдээллээ тухай бүрт шинэчлэн байршуулах, gov-altai.gov.mn сайтад тавих,	Жилдээ	-	-	Нөөцийн жагсаалт, бүртгэл ил тод, нээлттэй болсон байх	Төрийн албаны салбар зөвлөл	Агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар

тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох							
Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрэмзлэл санаачилга өрнүүлэх.	Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилга уриа, аянд нэгдэх.	Жилдээ	-	-	-Төрийн болон төрийн бус байгууллагаас санаачилсан аян арга хэмжээг дэмжиж, орон нутаг салбартаа зохион байгуулна.	Байгууллагын удирдлага	Агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар
	Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх.	Жилдээ	-	-	-Аймгийн Засаг даргын захирамжаар гэрээ байгуулах, хянах журам батлуулсан байна.	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хууль, эрх зүйн хэлтэс	Агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар
Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг	Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх	Жилдээ	-	-	-Төрийн бус байгууллагуудыг хяналт тавих нөхцлийг бодлогоор хангах. -Төрийн зарим чиг үүргийг Төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх, санхүүгийн хувьд дэмжих санхүүжилт, шийдвэрийн ил тод байдал, гүйцэтгэл	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Нийгмийн бодлогын хэлтэс	Иргэний нийгмийн байгууллагууд



 Улаанбаатар
 10000
 10000

10000

төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх					явцад олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлэх.		
--	--	--	--	--	---	--	--

ёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр


Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэх	Төрийн үйлчилгээний шат дамжлагыг цөөрүүлэн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор "Цахим-Алтай" арга хэмжээ хэрэгжүүлж, үйлчилгээний нэгдсэн төвөөр үзүүлэх, үйлчилгээний тоо, төрлийг нэмэгдүүлэх.	Жилдээ	-	-	50-иас доошгүй үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх.	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	Агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар
Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах.	Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангаж, Төрийн байгууллага, удирдах албан тушаалнууд жил бүр үйл ажиллагаагаа иргэдэд тайлагнаж хэвших.	Жилдээ	-	-	-Төрийн байгууллагууд үйл ажиллагааны тайлангаа иргэдэд тавьж, санал хүсэлт авсан байна.	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	Агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар

Handwritten notes and stamps in red ink, including a date stamp "2024.04.22" and a reference number "110A0042".


	Төрийн албан хаагчдын сахилга хариуцлага дээшлүүлэх зорилтын хүрээнд иргэдэд хууль эрх зүйн мэдлэг олгох сургалт сурталчилгааны ажлыг сумдад зохион байгуулах	Жилдээ	-	-	-10-аас доошгүй суманд арга хэмжээг зохион байгуулах. -Төрөөс шаардлагатай мэдээ мэдээлэл авах эрх нь хангагдана.	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хууль, эрх зүйн хэлтэс	Агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар
--	---	--------	---	---	--	---	---

урав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, хандив, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр

Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх	Төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтарч ажиллах.	Жилдээ	-	-	-Төсвийн ил тод байдал, иргэдийн оролцоог дээшлүүлэх - тод байдал иргэний оролцоог хангах тусгай төлөвлөгөө гаргаж хяналт тавих. - Төсөв, санхүүгийн төлөвлөлтийг сайжруулах, түүний тайлагналт, ил тод байдлыг хангах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх	Санхүү, төрийн сангийн хэлтэс	Агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар	
	2021 оны жилийн төсөв /1-р сарын 10-ны дотор/ 2020 оны төсвийн гүйцэтгэл /4-р сарын 1-ний дотор/, 2021 оны жилийн төсвийн төсөл /8-р сарын 15-ны дотор/ цахимд хуудсанд байршуулах	Жилдээ	-	-				
	Хувь хүн, хуулийн этгээдээс төсвийн байгууллагад өгсөн хандив, тусламж	Жилдээ				-Хандив тусламжийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу	Санхүү, төрийн сангийн хэлтэс	Агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар



	төсвийн бус орлого, түүний зарцуулалтыг мэдээлэх				www.shilendans.gov.mn байршуулах. -Хандив тусламжийн явц, гүйцэтгэлийн талаарх мэдээлийг байгууллагынхаа вэб сайт болон мэдээллийн самбарт байршуулж, иргэд олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлэх.		
	Гадаадын зээл тусламж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт болон төсөл, хөтөлбөр, арга хэмжээ бүрийн явц, гүйцэтгэлийг цахимаар хянах орчныг бүрдүүлж, нээлттэй, ил тод болгох, мэдээллийг сайжруулах.	Жилдээ			-Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн явц, гүйцэтгэлийг цахимаар хянах боломжийг судалж, хэрэгжүүлсэн байх -Төсвийн гүйцэтгэлийг govi-altai.gov.mn сайтад тавих	Санхүү, төрийн сангийн хэлтэс	Сумдын Засаг дарга нар
Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох	Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, явц гүйцэтгэлд иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх. Үүнд: Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан, Тариалан эрхлэлтийг дэмжих	Жилдээ			-Мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг хэвшүүлсэн байх. - Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах.	Хөрөнгө, оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Хүнс хөдөө аж ахуйн газар	Сумын Засаг дарга нар



 Д:ОА0042

Төсвийн төсөл лэлцэхэд олон нийтийн ролцоог хангах	сан, сум хөгжүүлэх сан Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх. Засгийн газрын www.iltod.mn, www.shilendans.com govi-altai.gov.mn сайтад тавих	Жилдээ			-Цахим хуудас болон бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төсвийн төсөлд санал авах мэдээллийг хүргэж, нутгийн хөгжилд иргэдийн оролцоог хангах ажлыг хэвшүүлэх.	Санхүү төрийн сангийн хэлтэс	Сумын Засаг дарга нар
Аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулах	Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг барагдуулах	Жилдээ	-	-	-Буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх арга хэмжээ авах -Хохирол төлөгдсөн байх	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар
өв. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга ил тод нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр							
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулах 11 дүгээр сарын 10-ны дотор/ Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл /шалгарсан болон	2021-01- 10	-	-	-Аймгийн цахим хуудас www.govi-altai.gov.mn тогтмол мэдээлэх ажлыг зохион байгуулах. -төрийн худалдан авах ажиллагаа тендертэй холбоотой мэдээлэл аймгийн цахим хуудас болон байгууллагын цахим хуудсаар мэдээлэгдсэн байх.	Орон нутгийн өмчийн газар	Агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар
		Тухай бүр	-	-		Орон нутгийн өмчийн газар	Агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар

	шалгарч чадаагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэл/						
	Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлан, Худалдан авах ажиллагаанд аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	Жилдээ, тухай бүр	-	-		Орон нутгийн өмчийн газар	Агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар
	Аудитын тайлан, дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан /бүтэн жилээр/	Жилдээ	-	-		Орон нутгийн өмчийн газар	Агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар

Тав.Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр

2.	Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах,	Жилдээ			Шударга ёсны үзэл санаа нийгэмд төлөвшиж, иргэн өөрт учирч байгаа хүндрэл, бэрхшээлийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлдэг байх нийгмийн сэтгэлгээ, хандлага өөрчлөгдсөн байх	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хууль эрх зүйн хэлтэс, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба	Агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар
		Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео, график, нийтлэл теле зохиомж, хөдөлгөөнт зураг	Жилдээ	-	-	Авлигын эсрэг үйл ажиллагаанд бүх оролцоог нийтийн хангасан байх.	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хууль эрх зүйн хэлтэс, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба	Агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар

<p>зурагт хуудас зэргийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл албан ёсны цахим хуудас байршуулах.</p>						
<p>Оюутан, сурагч, эцэг, эхийг хамруулсан шударга ёсны сэдэвт өдөрлөг, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах</p>	<p>Жилдээ</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>Хүүхэд, залуучуудын шударга зан чанар, ёс суртахууны үнэлэмж дээшлүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан байх.</p>	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хууль эрх зүйн хэлтэс, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба</p>	<p>Боловсрол, соёл урлагийн газар, сумдын засаг дарга нар, харьяа бүх байгууллага</p>

__оОо__

